

## **АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

### **НЭГ . ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

- 1.1 Товч танилцуулга

### **ХОЁР. ХОЛБООНЫ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР**

- 2.1 Жолоочийн даатгалын сан бүрдүүлэх, нөхөн төлбөрийн талаар
- 2.2 Мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, холбооны гишүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, мэдээлэл солилцох талаар
- 2.3 Даатгалын тохиолдлыг үнэн зөв тодорхойлж үйлчилгээ үзүүлэх Шуурхай албаны талаар
- 2.4 Албан журмын даатгалыг хэрэгжүүлэх, Жолоочийн даатгалын тухай хуулийн мэдээлэл, мэдлэгийг олон нийтэд олгох, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны талаар
- 2.5 Орон нутаг дахь салбарыг бэхжүүлэх талаар

### **ГУРАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ**

## **НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:**

### **1.1 Товч танилцуулга**

Албан журмын даатгагчдын холбоо нь Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрч, Удирдах зөвлөл баталсан дүрэм, Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хуулиар тусгайлан заасан эрх, үүргийг хэрэгжүүлж, үйл ажиллагаа явуулдгаараа бусад төрийн бус байгууллагаас ялгагдах онцлогтой.

Даатгалын тухай хуулийн 12<sup>1.3</sup> -д заасан бүтцийн хүрээнд албан журмын даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих, даатгалын тохиолдол, хохирогчдод олгосон нөхөн төлбөр, хохирогч болон жолоочийн даатгалтай холбоотой мэдээллийг нэгтгэх, мэдээлэл солилцох боломжоор хангах, жолоочийн даатгалын сан бүрдүүлэх, даатгалгүй, даатгалын хугацаа дуусан этгээд даатгалын тохиолдол гаргасан бол нөхөн төлбөр олгох, даатгалын тохиолдол, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгаа явуулах зэрэг үйл ажиллагааг Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хуулиудад заасны дагуу хэрэгжүүлж ажилладаг.

Холбооны үйл ажиллагаа жилээс жилд өргөжиж 2014 онд МИИС системийг анх ашиглаж эхэлж байсан бол МИИС системд хөгжүүлэлт, сайжруулалт тогтмол хийгдэж жолоочийн даатгалын хураамжийг цахимаар тооцоолж бэлэн бусаар төвлөрүүлж цахим даатгал хийх боломжтой болсон төдийгүй даатгалын 5 төрлийн 28 өгөгдлийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан мэдээлэл блокчэйн сүлжээнд ордог болоод байна. Мөн, даатгалын тохиолдлын цагдаагийн тодорхойлолтыг цахимаар даатгагч нарт гарган өгч даатгуулагчдад хөнгөн шуурхай үйлчлэх боломжийг бий болгов. Шуурхай албаны нэгдсэн дуудлагын төв ажиллуулж Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлагын төвтэй хамтран даатгалгүй болон даатгалын гэрээний хугацаа дууссан этгээдийг илрүүлж даатгалд хамруулах ажилд ахиц гаргалаа.

Жолоочийн хариуцлагын даатгалын үндсэн үйл ажиллагааг цахимжуулах нөхцлийг бүрдүүллээ.

2020 онд, Жолоочийн даатгалын тухай хуульд зааснаар Мэдээллийн сан, Даатгалын сан, Шуурхай алба гэсэн 3 нэгжтэй, орон нутагт 20 салбартай, нийт 41 ажилтны орон тоотой, өөрийн өмчлөлийн ажлын байртай, Жолоочийн даатгалын тухай хуулийн 21.2, Даатгалын тухай хуулийн 12<sup>1.8</sup> дахь заалтын дагуу үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнаж ажиллалаа.

## **ХОЁР. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Холбооны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталснаар 2020 онд 16 зорилт дэвшүүлж 51 ажил төлөвлөснөөс 49 ажлын гүйцэтгэлийг бүрэн хангаж 2 ажлын гүйцэтгэл улс оронд үүссэн цар тахлын нөхцөл байдалтай уялдан зөвхөн судалгааны түвшинд хийгдэж дараа оны төлөвлөгөөнд шилжлээ.

Удирдах зөвлөлийн хуралдаан, нийт ажилтнуудын хурал, орон нутгийн салбарын менежерүүдтэй хийсэн хурлын тэмдэглэлийг тухай бүр хөтөлж гарсан шийдвэр, үүрэг

даалгаврын биелэлт, Санхүүгийн зохицуулах хорооноос хийсэн шалгалтын тайланд дурдсан цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмжийн дагуу хийх ажлын хэрэгжилт, бусад шаардлагатай мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнаж СЗХороо, Удирдах зөвлөлөөс өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж ажиллав.

Холбооны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг заасан хугацаанд хэрэгжиж буй эсэхийг хянаж биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн нийт ажилтнуудын хурлаар хэлэлцүүлж тэмдэглэл үйлдэн үр дүн, сахилга хариуцлагыг тооцож ажиллалаа.

Ёс зүйн дүрэм, Нууцын жагсаалтыг Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулж нийт ажилтнуудад танилцуулж баримтлан ажиллах, Коронавируст халдварын цар тахлын улмаас гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжиж хатуу болон хэсэгчилсэн хөл хорио тогтоосонтой холбоотой гаргасан Гүйцэтгэх захирлын тушаал, гэнэтийн осол, байгалийн давагдашгүй хүчин зүйлээс сэргийлэх төлөвлөгөө, цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын үед онлайнаар болон хуваарийн дагуу эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн халдвар хамгааллын дэглэмийн дагуу ажиллахад хяналт тавьж ажиллалаа.

Тайлант хугацаанд, удирдах зөвлөлийн 8 удаагийн хуралдаанаар Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журамд өөрчлөлт оруулах, эд хөрөнгөд хийсэн тооллогын дүнгээс ашиглалтын явцад элэгдэлд орж эвдэрсэн, эдийн засгийн хувьд засварласан ч үр өгөөжгүй гэж дүгнэгдсэн 26 нэр төрлийн эд хөрөнгийг актлах тухай, 2021 оны сангийн орлого, зарлагын төсөв, 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах зэрэг үйл ажиллагаатай холбоотой 8 тогтоолыг Удирдах зөвлөл хэлэлцэж баталсан байна.

Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба, Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлагын төв, Монгол банк, Коллпро ХХК, Мобинет, ТВ9 болон бусад хэвлэл мэдээллийн газруудтай хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулан ажиллалаа.

2020 онд, бичиг хэргийн эргэлт нийт 851 байснаас, албан байгууллага, иргэдээс 359 албан бичиг, 59 өргөдөл, гомдлыг тус тус хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн албан байгууллага, иргэдэд нийт 434 албан бичиг явуулжээ. Тайлант хугацаанд хүлээж авсан 59 өргөдлөөс Холбооны ажилтнуудын хүсэлт, өргөдөл 25, бусад өргөдөл 34 байна. Гүйцэтгэх захирлын 64 тушаал гарснаас Хөдөлмөрийн тухай хууль хэрэгжүүлэхтэй холбоотой тушаал 10, Холбооны үйл ажиллагаатай холбоотой 54 тушаал батлагдсан байна. Мэдээллийн санд хийсэн мэдээлэл технологийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу Гүйцэтгэх захирлын 3 тушаал гарч гүйцэтгэл бүрэн хангагджээ. Нийт гарсан тушаал, өргөдөл, гомдол, хүсэлтэд хугацаанаас хоцроосон буюу хариу өгөөгүй, шийдвэрлэгдээгүй өргөдөл байхгүй байна. Дараа онд шийдвэрлэгдэхээр шилжсэн нөхөн төлбөртэй холбоотой өргөдөл 4 байна.

Гүйцэтгэх захирлын 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 02/02 тоот тушаалаар Холбооны эд хөрөнгийн тооллого явуулан эд хариуцагч тус бүрээр нүд үзэн тоолж эд хөрөнгийн картыг шинэчлэн бүртгэлжүүллээ. 2020 оны бичиг баримтуудыг албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу архивын нэгж үүсгэн 42 боть баримт, /санхүүгийн 23, шуурхай албаны 2, бичиг хэргийн 13, мэдээллийн сангийн 4, мэдээллийн сангийн нууцын мэдээлэлтэй холбоотой DVD, тендерийн 5 боть материал/-ыг архивт шилжүүллээ.

## **2.1 ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САН:**

Жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг эх үүсвэр тус бүрээр тооцож зардлын төсвийг батлагдсан зориулалтаар нь үйл ажиллагаандаа зарцууллаа.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-д заасан Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй даатгагч бүрээс төвлөрүүлэх хөрөнгийн хувь хэмжээг тогтоох тухай Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яамны хамтарсан “Хөрөнгө төвлөрүүлэх тухай” 2020 оны 10 сарын 22-ны өдрийн 33/199 дугаартай тушаалын дагуу даатгагчдаас төвлөрүүлэх 515,0 сая төгрөгөөс 372,4 сая төгрөгийг төвлөрүүлэв.

Даатгагчдаас төвлөрүүлэх хөрөнгө гэдэг нь нийт даатгуулагчдын өнгөрсөн онд төлсөн хураамжийн орлогын 1,6 хувиар тооцон авч байгаа хөрөнгө бөгөөд сүүлийн 3 жил тогтмол энэ хувь мөрдөгдөж байна.

Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийг Жолоочийн даатгалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан дараах үйл ажиллагаанд зарцуулах эрх зүйн зохицуулалтыг баримтлан

23.1.1.энэ хуулийн 18.1-д заасан нөхөн төлбөр олгох;

23.1.2.энэ хуулийн 24.1-д заасан жолоочийн даатгалын мэдээллийн сан хөтлөх;

23.1.3.шуурхай алба, сангийн үйл ажиллагааг санхүүжүүлэх;

23.1.4.зам, тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааг санхүүжүүлж байна.

Дээрх хуулийн заалтын хүрээнд, удирдах зөвлөлөөс баталсан төсвийн хэмжээнд жил бүрийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэн ажиллаж байна. Ингэхдээ даатгагчдаас төвлөрүүлсэн хөрөнгийг буцаан даатгалын компаниудын жолоочийн даатгалын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах, даатгагч нь даатгуулагчтай гэрээ байгуулахад үнэн зөв мэдээллээр хангаж жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг түргэн шуурхай бодитой тооцож өгөх, даатгагч компаниудын ажлыг хөнгөвчлөх, жолоочийн хариуцлагын даатгал хийх үйл ажиллагаанд гарч буй зардлыг хэмнэх зэрэгт зориулагдсаар ирсэн юм. Энэ төвлөрүүлсэн хөрөнгө нь мэдээллийн сангийн үйл ажиллагаанд зарцуулагдах зардлын 1/3- тэй тэнцэж байдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Өнгөрсөн хугацаанд жолоочийн хариуцлагын даатгалын шуурхай албаны үйл ажиллагааг онлайн болгон цахимжуулах, даатгуулагч, жолооч нар даатгалын тохиолдол гаргасан үедээ даатгалын компаний шуурхай алба, тээврийн цагдааг хүлээж зам дээр удаан зогсож цагаа үрэх, бухимдах, замын хөдөлгөөний ачаалал үүсгэхийг багасгахын тулд техник, технологийн шийдлийг нэвтрүүлэн ажиллав. Даатгагчдаас төвлөрүүлж байгаа хөрөнгө нь хүрэхгүй байгаа ч гэсэн жолоочийн даатгалын сангаас санхүүжүүлэн, даатгагч, даатгуулагчид аль аль нь ашиглах боломжтойгоор даатгалын тохиолдлын дуудлагыг улсын хэмжээнд 24/7 цагаар 18001177 тусгай дуарын утсаар болон АЖД аппликейшнээр хүлээн авч холбооны дуудлагын нэгдсэн програмд оруулснаар 3 минутын дотор шийдэх боломжийг бүрдүүлэн ажиллаласан нь даатгагч, даатгуулагчийн төлөө хийсэн үйл ажиллагаа юм.

Даатгалын сан нь 2020 онд, 27 өргөдөл хүлээн авч, холбогдох материалуудыг судлан Жолоочийн даатгалын тухай хуулийн 13.2-т заасан үүргээ биелүүлээгүй 18 хүнд нөхөн төлбөр олгохоос татгалзаж, 5 хүнд даатгалын сангаас нөхөн төлбөр олгож, 4 өргөдөл дараа онд хяналтын шатанд шилжээд байна.

2020 оны байдлаар жолоочийн даатгалын сангаас олгосон нөхөн төлбөрийн эргэн төлөлтийн үлдэгдэл 62 үүрэг гүйцэтгэгчид холбогдох **89,8** сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд тайлант хугацаанд 23 иргэн нөхөн төлбөрийг бүрэн барагдуулж нийт 46,957,5 мянган төгрөг төвлөрүүлэв.

2019 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж, Сүлд аудитаар хөндлөнгийн аудитыг хийлгэн, дүгнэлтийг Удирдах зөвлөлд танилцуулж Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүллээ.

Жолоочийн даатгалын сангийн 2020 жилийн эцсийн санхүүгийн тайланг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн акт, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг баримтлан анхан шатны баримтад тулгуурлан бүртгэж тайлагнав.

## **2.2 МЭДЭЭЛЛИЙН САН:**

ЖДТХуулийн 24 дүгээр зүйлд зааснаар мэдээллийн сан нь жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ, даатгалын тохиолдол, хохирогчид олгосон нөхөн төлбөр, даатгагч, даатгуулагч, хохирогчийн болон жолоочийн даатгалтай холбоотой бусад мэдээллийг МИИС, МИИС++ системд нэгтгэн даатгагч нарт үнэ төлбөргүй үйлчлэхийн зэрэгцээ холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, даатгалын мэргэжлийн холбоод, даатгагч, даатгуулагчдыг мэдээлэл солилцох боломжийг ханган сүүлийн үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэн ажиллаж байна.

Мэдээллийн сангийн сервер төхөөрөмжүүдийн мониторинг системийн PRTG Network monitor, Cisco ASDM, VirtualVM програмуудын тусламжтайгаар сервер төхөөрөмжүүдийн ажиллагаанд өдөр бүр хяналт тавьж системийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллалаа. Дамжих мэдээлэл нэмэгдэж байгааг харгалзан сүлжээний интернет гарцын хурдыг 6 Mbps болгож нэмэгдүүллээ.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, ажилтнуудын компьютерыг хортой кодоос хамгаалах, Kaspersky Internet Security вирусны програмын өмнөх оны лицензийн хугацааг сунгаж лицензийг суулгаж тохируулан ажиллах нөхцлөөр хангалаа.

Цахим бичиг баримтыг хадгалахаар тус серверийг тохируулан ERP системийн баазыг суулгаж ажиллагаанд оруулсан. Ингэснээр дотоод ERP систем хэвийн ажиллах боломжтой боллоо. Цахим бичиг баримтыг хадгалах, солилцох, ажлын албаны цахим архив үүсгэх, мэдээллийн сангийн мэдээллийг нөөцлөх төхөөрөмжийг хэвийн ажиллагаанд оруулж зайнаас ажиллах боломжтой болгов.

Замын хөдөлгөөний удирдлагын төвөөс авсан зам тээврийн ослын видео мэдээллийг хадгалах, шуурхай албаны 1800-1177 дугаарын утсанд ирсэн дуудлагын /audio/ бичлэгийг нөөц байдлаар хадгалахтай холбогдуулан сервер бэлтгэж холбогдох эрхийн тохиргоо, хадгалах байршил, сүлжээний холболтыг хийж ажилд оруулав.

Холбооны “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”-д мэдээлэл технологийн эрсдлийн үнэлгээг хөндлөнгийн CISA гэрчилгээ эсхүл дүйцэх түвшний гэрчилгээ бүхий аудиторoor COBIT тогтолцоонд суурилсан мэдээллийн технологийн тусгайлсан хяналт аудит хийлгэх талаар заасныг хэрэгжүүлж аудит хийлгэлээ.

Нэгдсэн дуудлагын 18001177 утсанд ирэх дуудлага бүрийг мэдээллийн санд бүртгэх програмын шийдэл, дуудлага шилжүүлэх, ярианы бичлэг хадгалах талаар тодорхой шийдийг КоллПро ХХК тай хамтран шинээр нэвтрүүлэн ажиллалаа. МИИС системийн даатгалын дуудлага бүртгэх хэсэгт шинээр Дуудлага өгсөн огноо, тохиолдол болсон огноо, бүртгэсэн огноо, дуудлага өгсөн утас, улсын дугаар, бүртгэсэн хэрэглэгч, зип код, байршил, шийдвэрлэлт, төрөл гэсэн 10 төрлөөр хайлт хийх боломжтой болгов.

Энэ шийдлийг хэрэгжүүлэхээр холбогдох гэрээг хийж холболтын 2 сервисийг шинээр гаргаж холболт хийж, ирсэн дуудлага бүр мэдээллийн санд дуу хоолойн бичлэгийн хамтаар бүртгэгддэг болголоо. Дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийн даатгалын гэрээг байгуулахад хугацаа нь 1 жилээр гарч байгааг Банкны болон ҚРАҮ хураамж төлөлтийн сервис дээр засч сайжруулав. Мөн ҚРАҮ -ээр хураамж төлсөн тохиолдолд төлсөн хугацааг авах нэмэлт холболтыг хийж ажилд оруулав.

Холбооны вэб сайт /www.ami.mn/-ыг шинэчлэх ажлыг 2020 оны 02-р сарын 17-ний өдрөөс эхлүүлэн 2020 оны 03-р сарын 24-ний өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэн үйл ажиллагаанд нэвтрүүлж, үндсэн болон дагалдах цэс, тэдгээрийн агуулгыг шинэчлэн, өнгө загвар, дизайны хувьд орчин үеийн хэв маягт нийцүүлээ. Сайтыг шинэчлэх ажлын явцад нийт 74 мэдээ, нийтлэлийг шинээр болон хуучин сайтаас шилжүүлэн байршуулсан бол гарц нэвтрүүлэг, видео шторк зэрэг нийт 34 видео мэдээлэл, 2012 оноос хойших үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, 2018-2020 оны стратеги төлөвлөгөө зэрэг тайлан мэдээлэл, Зарулем сэтгүүлийн 2018 он, 2019 он, 2020 оны эхний 3 дугаар, Соёмбо нэвтрүүлгийн 7 дугаар, холбооны танилцуулга, алба, сангийн танилцуулга гэх мэт нийт давхацсан тоогоор 130 гаруй контент мэдээллүүдийг байршуулсан байна.

### 2.3 ШУУРХАЙ АЛБА:

Шуурхай алба нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу жолоочоос шалтгаалан гарсан зам тээврийн ослын талаарх мэдээллийг дуудлагын нэгдсэн төвийн 4 оператор 1800-1177, 70101177 утсаар даатгалын тохиолдлын дуудлагыг хүлээн авч, даатгагч нарт шилжүүлэх, даатгалгүй, даатгалын гэрээний хугацаа дууссан жолоочийн дуудлагад үйлчлэх, МИИС системд бүртгэх ажлуудыг гүйцэтгэлээ. Тайлант хугацаанд, дуудлагын нэгдсэн төвөөр 117 даатгалын тохиолдлын дуудлага хүлээн авсан байна. Даатгалын компаниудын 5730 даатгалын тохиолдлын дуудлага МИИС системд бүртгэгдсэнээс нийслэлд 84% нь, орон нутагт 16% нь бүртгэгджээ.

Шуурхай албаны болон мэдээллийн сангийн лавлагаа, бусад **2994** дуудлага хүлээн авч мэдээ, мэдээллээр хангаж ажиллалаа.

| Сар  | Хууль<br>тогтоомжийн<br>лавлагаа | МС-ийн<br>лавлагаа | ДС-ийн<br>лавлагаа | Санал<br>гомдол | ДК-ийн<br>утас,<br>байршил | Бусад | Нийт |
|------|----------------------------------|--------------------|--------------------|-----------------|----------------------------|-------|------|
| Нийт | 212                              | 1324               | 364                | 79              | 446                        | 569   | 2994 |

Шуурхай алба нь даатгалын тохиолдлын хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх аяныг үргэлжлүүлж цар тахалтай холбоотой хөл хориотой,

өндөржүүлсэн байдлын зэрэгт шилжсэн байсан ч 2020 онд идэвхитэй ажилласнаар хугацаа хэтэрч хуримтлагдсан нөхөн төлбөрийн үлдэгдлийг 35,7%-аар бууруулж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал буцаан төлөлт 61%-аар өссөн байна. 2020 онд 46,9 сая төгрөг буцаан төлүүлж жолоочийн даатгалын санд төвлөрүүлэв.

Тайлант хугацааны нөхөн төлбөрийн эргэн төлөлтийн үлдэгдэлтэй 57, энэ онд шинээр нөхөн төлбөр авсан 5, нийт 62 үүрэг гүйцэтгэгчийн мэдээлэл, төлбөрийн үлдэгдлийн хамт Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгүүлээ. Нөхөн төлбөрийн эргэн төлөлтийн үлдэгдэлтэй 6 этгээдийн 15,6 сая төгрөгийн материалыг ШШГЕГ-т шилжүүлж, 14,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй 7 материалыг шүүхэд шилжүүлсэн, 20,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй 13 нөхөн төлбөрийн эзнийг эрэн сурвалжлуулж, 12,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй 11 материалд хаяг тодруулалт хийж байна. Одоогоор 22,3 сая төгрөгийн үлдэгдэлтэй 22 хүн эргэн төлөлтийг хуваарийн дагуу хийж байна.

Цагдаагийн ерөнхий газраас ослын тодорхойлолтыг цахимаар өгөх, жолоочийн үнэмлэхний мэдээллийн сангаас мэдээлэл дамжуулахтай холбоотой хамтран ажиллах гэрээний дагуу МИИС системээр дамжуулан цахим хэлбэрээр 6,150 тодорхойлолтыг бүртгэж, холбогдох даатгалын байгууллагуудад илгээсэн байна. Шуурхай албаны үйл ажиллагааг сайжруулах, даатгалын байгууллагаас даатгалын тохиолдлыг бие даан тодорхойлох, даатгалын тохиолдлыг бүртгэх, үзлэг хийх, нөхөн төлбөрийг түргэн шуурхай шийдвэрлэх, Жолоочийн даатгалын тухай хуулийн 4.1.3 дахь заалтыг зөрчиж жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдаагүй, гэрээний хугацаа дууссан үедээ замын хөдөлгөөнд оролцсон зөрчлийг бууруулах чиглэлээр Замын хөдөлгөөний удирдлагын төвтэй хамтран ажиллах гэрээний дагуу 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн Улаанбаатар хотын замын хөдөлгөөний удирдлагын төвд шуурхай албаны ажилтныг ажиллуулж байна. ТЦА-ны Замын хөдөлгөөн зохицуулах хэлтэс, УБ хотын ЗХУТ-ын Хөдөлгөөн зохицуулалт, хяналтын хэлтэс, Зөрчил бүртгэлийн хэлтсүүдийн алба хаагч нартай хамтран Замын хөдөлгөөний хяналтын камерт бичигдсэн зам тээврийн 2,132 ослыг фото зураг болон дүрс бичлэгээр баримтжуулан, холбогдох даатгалын компаниудад мэдээлэл өгч, зам тээврийн ослын мэдээллийн түүх үүсгэн, хөдөлгөөний түгжрэл саатлыг шуурхай арилгах зорилгоор даатгагч нартай холбогдон, зохицуулалт хийж ажиллалаа.

2020 онд дээрхи 2,132 зам тээврийн ослыг фото зураг, видео дүрс бичлэгээр баримтжуулан Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн серверт хадгалан зам тээврийн ослын мэдээллийн түүх үүсгэсэн байна.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдаагүй болон даатгалын хугацаа дууссан тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцвол замын зөрчил бүртгэлийн телекамерт баримтжуулан даатгалд хамрагдахыг сануулах, анхааруулах мессэж хүргүүлэх ажлыг гүйцэтгэхээр бэлтгэл хангалаа.

## **2.4 СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР:**

Жолоочийн даатгалын тухай хууль, холбогдох дүрэм, журам, жолоочийн хариуцлагын даатгалын ач холбогдол, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт сурталчилгаа хийх зорилтын хүрээнд, МҮОНРадиоогийн “Гурван Эрдэнэ”студи, ТВ телевизийн “Гарц” нэвтрүүлэг, За рулём Монголия сэтгүүл, VIP76.mn сайт зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж дараах үйл ажиллагааг явууллаа.

-МҮОНРадиоогийн “Гурван Эрдэнэ” студитэй хамтран ажиллах гэрээ байгуулж Жолоочийн хариуцлагын даатгалын үйл ажиллагаанд нэвтрүүлж буй цахим үйлчилгээ, Зам тээврийн ослын хор холбогдол түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, Хүүхдийг зам тээврийн ослоос хэрхэн сэргийлэх зэрэг сэдвээр сурвалжлага, ярилцлага, нийтлэл зэрэг нэвтрүүлэг 8 удаа бэлтгэж олон нийтэд хүргэсэн.

- TV9телевизийн “Гарц” нэвтрүүлгээр Албан журмын даатгагчдын холбооноос даатгалын үйлчилгээнд технологийн дэвшлийг нэвтрүүлж жолоочийн хариуцлагын даатгалын гэрээг цахимаар болон киоск, пос машин ашиглаж хийх, даатгалын үйлчилгээний шуурхай, хүртээмжтэй байдлыг хангах, зам тээврийн ослын хохирогчийн эрх ашгийг хамгаалах хуулийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор зам тээврийн осол буюу даатгалын тохиолдлын дуудлагыг нэгдсэн байдлаар 1800-1177 дугаарт хүлээн авах, АЖД аппликейшн ашиглаж дуудлага өгөх,авах; даатгалын компаниуд хохирогчийн хохирлыг бүрэн барагдуулж буй эсэхэд хэрхэн хяналт тавьж байгаа талаар болон “Асимон брокерс” ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй түгжрэлгүй үйлчилгээ санаачлагын хүрээнд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг киоск, пос машин ашиглаж хийх тухай телевизийн нэвтрүүлгүүдийг олон нийтэд хүргэж ажилласан.

- Замын хөдөлгөөнд аюулгүй оролцох, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх дадал хэвшил, соёлыг олон нийтэд төлөвшүүлэх чиглэлээр За рулём Монголия сэтгүүлтэй хамтран ажиллаж Үзэгдэлт хангалтгүй нөхцөл, Шөнийн жолоодлого, Замын хөдөлгөөнд оролцох соёл, Дуут дохио ашиглах соёл, Замын хөдөлгөөнд Та-Би-Та зарчмаар оролцох соёл, Хурдаа тохируулах соёл гэсэн 6 сэдвээр мэдээлэл бэлтгэн тус сэтгүүлд хэвлүүлсэн. Уг сэтгүүл сар бүр 10,000 ширхэг, нийт 60,000 мянган ширхэг хэвлэгдэж олны хүртээл болгов. Тус сэтгүүлийн 38-р нүүрэнд хэвлэгддэг ЗРМ интерактив булангийн иргэд, даатгуулагч нарын асуултад хариулт өгч ажиллаж байна. Мөн сэтгүүлийн “Замын цагдаагийн булан”-гийн мэдээллийн ивээн тэтгэгчээр ажилласан бөгөөд тус буланд АЖДХ-оос болон Тээврийн цагдаагийн албанаас иргэдийн асуултад өгсөн тайлбар, тодруулга, замын хөдөлгөөний дүрмийн тест, хариулттайгаа нийтлэгдэж байна.

Зорилтот бүлэгт чиглэсэн сургалтыг дараах байгууллагуудад зохион байгууллаа.

- Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний төв НӨҮГ-ийн ажилтан алба хаагчдад
- “Таван Богд”ХХК-ийн ажилтан, түгээлтийн жолооч нарт
- Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний Баян хошуу дэд төвийн “Бизнес инкубатор, сургалт үйлдвэрлэлийн төв”-ийн харилцагч нарт
- Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбооноос зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээний байгууллагуудын удирдах ажилтнууд, авто оношилгооны төвүүдийн инженер техникийн ажилтнууд, мэргэшсэн инженерийн зэрэг горилогч нарт зохион байгуулсан онлайн сургалтуудад Жолоочийн даатгалын тухай хууль түүнийг хэрэгжүүлэх нь сэдвээр сургалт хийсэн байна.

Тээврийн цагдаагийн албатай хамтран сургалт, сургалчилгааны хөтөлбөр боловсруулж даатгуулагчдад, мөн сургуулийн өмнөх болон, ЕБС-ийн сурагчдад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах, замын

хөдөлгөөнд оролцох зөв дадалд хэвшүүлэх, зорилтот бүлгүүдэд чиглэсэн дараах ажлыг хийсэн байна:

- Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулах, жолоочийн сахилга, хариуцлага соёлыг дээшлүүлэх, хамтран ажиллах үйл ажиллагааны хүрээг тогтоох зорилгоор ТЦА-тай байгуулсан хоёр талын хамтын ажиллагааны “Санамж бичиг”-ийн хүрээнд зам тээврийн осол, хэргийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, осол гарах болсон шалтгаан нөхцөлийг тогтоох чиглэлээр хамтран судалгаа хийх, жолоочийн даатгалд хамрагдах, түүний ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлан таниулах жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хяналт, шалгалтын ажлыг хамтран зохион байгуулах ажлыг ТЦА-ны зүгээс дэмжин ажиллаж байна. Энэ үйл ажиллагаанд Төв, Өвөрхангай, Орхон, Завхан аймгийн ЗЦТасгийн бие бүрэлдэхүүн идэвх санаачлагатай, хууль, дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.
- Мөн ТЦА болон “Системийн динамик загварчлал”ТББ-тай хамтран Монгол улсын хэмжээнд зам тээврийн осол гарч буй байршил, замын хамгийн аюултай цэгүүдийг тодорхойлох судалгааны ажлыг гүйцэтгэв.
- Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2020 оны 05 сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтыг сайжруулах зорилгоор автотээврийн хэрэгсэлд RFID ялтас наах ажлыг зохион байгуулах, мөн зөвлөмжийн 6-д “Зам тээврийн ослын судалгаанд үндэслэж, хор уршигт дүгнэлт хийж орон нутгийн замд хурд хэмжих төхөөрөмж байрлуулан ашиглаж, тээврийн хэрэгслийн хурдыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэх зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг үүрэг болгосны дагуу Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж СЗХорооноос дэмжсэний дагуу ТЦАлбанаас хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх зардлын тодорхой хэсгийг Жолоочийн даатгалын сангийн хөрөнгөөс гаргах шийдвэр гаргуулав.

Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн чиглэлийн дагуу сургалт, сурталчилгааны ажлын үр дүнг тооцох зорилгоор Санхүү эдийн засгийн их сургуулийн судалгааны багаар нийслэл болон 14 аймгаас санамсаргүй, түүврийн аргаар замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч, даатгуулагч 2000 хүнийг хамруулсан судалгаа авах, дүгнэлт хийх ажил зохион байгууллаа. Судалгааны дүнгээс товч дурдвал:

Замын хөдөлгөөнд оролцож байсан судалгаанд оролцогчдын 95.8 хувь жолоочийн хариуцлагын даатгалтай, 62.1 хувь нь жолоочийн хариуцлагын даатгалын зэрэгцээ тээврийн хэрэгслийн сайн дурын даатгалтайгаар замын хөдөлгөөнд оролцож байсан байна. Уг судалгаанаас үзэхэд, Холбооноос явуулж буй жолоочийн хариуцлагын даатгалд даатгуулахын ач холбогдол, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх сургалт сурталчилгааны зорилго нь хангалтай хэмжээнд хэрэгжиж, иргэдэд хүрсэн байна гэж дүгнэжээ.

Холбогдох хуулийг хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудтай хамтран зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн Нэг хором, Амин бүс, Орон нутгийн зам хөдөлгөөний соёл, Яараад яах

вэ зэрэг сурталчилгааны ажлуудын хүртээмжтэй байдлыг судлан үзэхэд судалгаанд оролцогчдын 90 гаруй хувьд хүрсэн нь зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдлыг буруулахад чиглэсэн сурталчилгаа нь зорилтот бүлэгтээ хүрсэн байна гэж судалгааны баг үзжээ.

## **2.5 ОРОН НУТАГ ДАХЬ САЛБАРЫГ БЭХЖҮҮЛЭХ ТАЛААР:**

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 211, 212 дугаар тогтоолоор баталсан “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”, “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын мэдүүлгийн маягт, гэрээний стандарт загвар” батлах тухай журам, мөн хорооны 2018 оны 213 дугаар тогтоолоор баталсан “Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”, 2019 оны 02 тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт” зэрэг салбарын эрх зүйн актуудад нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдсон саналуудыг боловсруулж хэлэлцүүлэг, санал асуулга зохион байгуулж саналыг нэгтгэн Санхүүгийн зохицуулах хороонд 2020 оны 01 дүгээр сарын 10 ны өдрийн 02/12 тоотой, 2020 оны 6 дугаар сарын 09, мөн сарын 18, 10 дугаар сарын 16-ны өдрүүдэд fgc.mn хаягаар цахим шуудангаар хүргүүлж ажиллалаа.

Холбооны хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэд мониторинг хийж нийт ажилтнуудын хурлаар хэлэлцүүлэн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тогтвортой ажиллах боломж олгох, урамшуулах болон хариуцлага тооцох зэрэг холбогдох заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулж Гүйцэтгэх захирлын 2020 оны 5 сарын 20-ны өдрийн 02/17 дугаар тушаалаар баталж хэрэгжүүлж байна.

Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, эдгээрийг даган гарсан журам зааврууд, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан шийдвэр, зааврууд мөн ажил олгогч, ажилтнуудын хоорондын харилцааг зохицуулдаг эрх зүйн актуудыг судлан Холбооны үйл ажиллагаанд мөрдөгдөх актуудыг сонгон эмхтгэж гарын авлагыг бэлтгэн хэвлүүлсэн байна.

Холбооны орон нутаг дахь салбаруудын санхүү бүртгэл, жолоочийн даатгалын сангийн хүлээх чиг үүргийн хүрээнд орон нутагт хийгдэж буй өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Холбооны ажилтнууд, салбарын менежерүүд 2019 онд даатгалын хохирол үнэлгээ, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, даатгалын тохиолдлын газар дээр үзлэг шинжилгээ хийх сургалтуудад, 2020 онд даатгалын зуучлагчийн сургалтанд тус тус хамрагдаж тухайн мэргэшлээр үйл ажиллагаа явуулах эрхийн гэрчилгээ авсан. Орон нутаг дахь салбарын менежерүүдтэй улирал тутам онлайнаар заавар зөвлөгөө өгч, санал бодлыг нь сонсож ажиллалаа.

2020 онд, Холбооны Вэб сайтад нийт 69955 хандалт бүртгэгдэж 405394 хуудас мэдээлэл авсан байна.

Тайлант хугацаанд, улсын хэмжээнд Жолоочийн хариуцлагын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, замын хөдөлгөөнд оролцохгүй байгаа тээврийн хэрэгслийн судалгаа гаргах зорилгоор нэг сарын ажил 2020 оны 8 дугаар сард зохион байгуулж тус аяны хүрээнд 22446

даатгалын гэрээг байгуулж жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдалтыг өмнөх онуудтай харьцуулвал бараг 2 дахин нэмэгдүүлсэн байна.

Даатгалд хамруулахаар орон нутагт ажилласан байдлыг өмнөх 2 жилийн мөн үеийн тоон мэдээтэй харьцуулвал:

| №           | Нутаг дэвсгэр | ЖХДаатгалд хамрагдсан байдал                    |                 |                 |
|-------------|---------------|-------------------------------------------------|-----------------|-----------------|
|             |               | /заасан хугацаанд МИИС системд бүртгэгдсэн дүн/ |                 |                 |
|             |               | 2018.08.25-9.25                                 | 2019.08.25-9.25 | 2020.08.25-9.25 |
| 1           | Архангай      | 493                                             | 479             | 692             |
| 2           | Баян-Өлгий    | 480                                             | 500             | 1032            |
| 3           | Баянхонгор    | 622                                             | 635             | 1037            |
| 4           | Булган        | 329                                             | 322             | 454             |
| 5           | Говь-Алтай    | 306                                             | 306             | 573             |
| 6           | Говь-сүмбэр   | 168                                             | 131             | 229             |
| 6           | Дархан-Уул    | 1062                                            | 916             | 1252            |
| 7           | Дорноговь     | 745                                             | 608             | 1354            |
| 8           | Дорнод        | 584                                             | 601             | 899             |
| 9           | Дундговь      | 202                                             | 172             | 346             |
| 10          | Завхан        | 359                                             | 405             | 629             |
| 11          | Орхон         | 1428                                            | 1314            | 1940            |
| 12          | Өвөрхангай    | 758                                             | 775             | 1419            |
| 13          | Өмнөговь      | 1239                                            | 1158            | 4213            |
| 14          | Сүхбаатар     | 302                                             | 275             | 499             |
| 15          | Сэлэнгэ       | 815                                             | 644             | 1187            |
| 16          | Төв           | 482                                             | 387             | 632             |
| 17          | Увс           | 373                                             | 479             | 652             |
| 18          | Ховд          | 379                                             | 404             | 1248            |
| 19          | Хөвсгөл       | 671                                             | 614             | 1559            |
| 20          | Хэнтий        | 461                                             | 440             | 600             |
| <b>Нийт</b> |               | <b>12258</b>                                    | <b>11,565</b>   | <b>22,446</b>   |

Мөн дээрх аяны хугацаанд, орон нутгийн хэмжээнд 92,631 тээврийн хэрэгсэл жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдах шаардлагагүй буюу ашиглагдахгүй байгаа гэсэн судалгаа гарсан байна.

Орон нутаг дахь салбарын менежерүүд шуурхай дуудлагын болон лавлах утсаар нийт 5864 дуудлага 24 цагаар хүлээн авч 20 даатгалын тохиолдлын дуудлагад биечлэн очиж ажилласан байна. Тайлант хугацаанд “Яараад яахав”, “Бүсээ зүү, Хурдаа хас” зэрэг самбарыг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн төв болон хот хоорондын хатуу хучилттай замуудад байршуулсан байна. Мөн, тухайн аймгийн Авто тээврийн үндэсний төв, Тээврийн цагдаагийн тасаг, даатгалын компаниуд хамтран зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, мэдээлэл, сурталчилгааны самбарыг улсын чанартай авто замын дагуу байршуулж ажилласан байна. Тухайлбал Дорнод аймагт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд нийт 16,0 сая төгрөгийн өртөгтэй зам тээврийн осол, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хот

хооронд болон улсын чанартай авто зам дагуу хөдөлгөөнд оролцогч нарт хандсан Мэдээлэл сурталчилгааны самбарыг аймгийн хэмжээнд авто замын дагуу байршуулсан байна.

Тайлант хугацаанд орон нутгийн хэмжээнд Завхан аймгаас Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгохыг хүссэн 2 өргөдөл гаргасан. Жолоочийн даатгалын тухай хуульд заасны дагуу Жолоочийн даатгалын сангаас 588,000 төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон. 2 дахь өргөдлийн хувьд, тээврийн хэрэгслийн өмчлөгч жолоочийн хариуцлагын даатгалтай байсан тул холбогдох хуулийн заалтыг үндэслэн жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгохоос татгалзсан байна.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтыг 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсонтой холбогдуулан 2020 оноос Жолоочийн даатгалын санд авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувийг төвлөрүүлээгүй боловч СЗХорооноос тавьсан шаардлагын дагуу Хэнтий аймаг – 6,500,000 төгрөг, Хөвсгөл аймаг – 8,300,000 төгрөгийг Жолоочийн даатгалын санд төвлөрүүлсэн.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалтын дагуу Жолоочийн даатгалын санд 2,684,900 төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Үүнд:

1. Дорноговь аймаг – 1 хүн 1,795,000 төгрөг бүрэн төлж барагдуулсан
2. Орхон аймаг – 1 хүн 497,900 төгрөг бүрэн төлж барагдуулсан
3. Завхан аймаг – 1 хүн 392,000 төгрөг. 2020 онд нөхөн төлбөр авсан бөгөөд Жолоочийн даатгалын сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх гэрээний хавсралтад заасан хуваарийн дагуу буцаан төлөлтийг хийж байгаа.
4. Говь-Алтай аймаг – Х.Батсайханаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэхээр Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандсан бөгөөд шүүхийн шатанд байгаа болно.

Тайлант хугацаанд орон нутаг дахь салбаруудаар нийт 153 иргэн, даатгуулагч өөрийн биеэр ирж заавар зөвлөгөө, мэдээлэл авсан байна.

Холбооны шуурхай албаны ажиллах журмын дагуу салбарын үйл ажиллагааг явуулж, дуудлагыг 24 цагаар авч бүртгэн, тухайн долоон хоногийн мэдээг даваа гариг бүр [operator@ami.mn](mailto:operator@ami.mn) хаягаар явуулж хэвшсэн байна.

Тайлант хугацаанд Жолоочийн даатгалын сангийн даатгалын тохиолдлын 20 дуудлагыг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Үүнд:

- Даатгалтай – 7 дуудлагыг даатгалын компани руу шилжүүлсэн.
- Хоорондоо тохиролцож, хохирлоо буруутай этгээд өөрөө барагдуулсан – 11
- Нөхөн төлбөр олгохоос татгалзсан – 1
- Нөхөн төлбөр олгосон – 1

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй даатгалын компанийн салбар, зуучлагч, төлөөлөгчдийг оролцуулан жилд 2-оос доошгүй уулзалтыг зохион байгуулж, уулзалтын үеэр хамтарсан хяналт шалгалт хийх, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, Жолоочийн даатгалын тухай хуулийн ач холбогдолыг тайлбарлан таниулах сургалт суртчилгааны ажлыг хамтран зохион байгуулах зэрэг асуудлаар ярилцаж уялдаа холбоотой ажиллаж байна.

Мөн тухайн орон нутгийн Цагдаагийн газрын дэргэдэх Тээврийн цагдаагийн тасагтай уулзалт хийж хамтарсан хяналт шалгалт зохион байгуулах, хамтран ажиллах талаар санамж бичгийг аймаг бүр байгуулан ажиллаж байна.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалтай холбоотой сургалтыг тухайн аймгийн иргэд, даатгуулагч болон авто тээврийн үйл ажиллагаа явуулдаг тээврийн компани, Онцгой байдлын ерөнхий газар, ерөнхий боловсролын сургууль, цахилгаан түгээх компани зэрэг төрийн болон хувийн өмчит аж ахуй нэгжид сургалт зохион байгуулсан байна. Нийлбэр дүнгээр нийт 1157 иргэн, даатгуулагч сургалтад хамрагдсан байна.

Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй Банк бус санхүүгийн байгууллагад сургалт хийж жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын өмчлөгчийн нэрээр гэрээ хийхийг анхааруулж ажилласан байна. Ингэснээр даатгалын нөхөн төлбөр авахад даатгуулагчид ямар нэгэн чирэгдэл үүсэхгүй болсон байна.

2020 онд орон нутагт 265,614 жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээ хийгдсэн байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 0,6 хувиар өссөн дүнтэй байна. Тухайн орон нутагт гарсан даатгалын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авч холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлжээ. Тухайлбал Сэлэнгэ аймагт Авто тээврийн үндэсний төвийн дарга Миг даатгалд давуу эрх олгож байгаа тухай гомдлыг бусад даатгалын компаниуд гаргасан бөгөөд гомдлын дагуу шалгахад нийт жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчдын 67 хувь нь Миг даатгалд даатгуулсан байсан тул Аймгийн засаг даргад энэ тухай танилцуулж хариуг өгсөн байна.

Дорнод аймаг дахь салбарын менежер иргэд, даатгуулагчдад түргэн шуурхай үйлчлэх Нэг цэгийн үйлчилгээ бий болгох санаачилгыг гаргаж орон нутгийнхаа холбогдох хүмүүстэй уулзан 7 даатгалын компанийг нэг цэгт төвлөрүүлэн даатгалын Нэг цэгийн үйлчилгээг нээн ажиллуулсан байна.

## **ГУРАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ:**

2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр 16 зорилтын хүрээнд 51 ажил гүйцэтгэхээр төлөвлөснөөс,

- 8.25 Мэдээллийн аюулгүй байдлын журмыг хэрэгжүүлэх цахим гарын үсгийг МИИС системийн админ хэсэгт нэвтрүүлэх ажил улс оронд үүссэн цаг үеийн байдлаас хамаарч хойшлоод байна.

ЖДТХуулийн 18.1.3-т зааснаар бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тодорхой бус тохиолдолд жолоочийн даатгалын сан хохирогчийн өргөдлийг үндэслэн нөхөн төлбөр олгох тохиолдолд жолоочийн даатгалын сангаас олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс нэхэмжлэх боломжгүй нөхцөл байдал үүснэ. Энэ мэт олон асуудлыг яаралтай шийдвэрлэхийн тулд Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг яаравчлах нь зүйтэй байна.

Тээврийн хэрэгслийн өмчлөгч хүчин төгөлдөр даатгалын гэрээтэй, өөр жолоочоор машинаа бариулж замын хөдөлгөөнд оролцсон үед даатгалын тохиолдол гаргахад Иргэний хуульд заасны дагуу шийдвэрлэхгүйгээр “Нэр дурьдагдаагүй жолооч” гэсэн хууль бус нэр томъёо гарган нөхөн төлбөр өгөхөөс татгалзаж байгаа даатгагчдад тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар нэг мөр ойлголттой болгох зүй ёсны шаардлага гарч байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

## ТАЙЛАН БИЧСЭН:

Албан журмын даатгагчдын  
холбооны гүйцэтгэх захирал

Д.ЦЭВЭЭНЖАВ

Ажлын албаны дотоод хяналт хариуцсан  
ахлах ажилтан

Б.Эрдэнэцэцэг

Даатгалын сангийн дарга, ерөнхий санхүүч

С.Хишигзаяа

Мэдээллийн сангийн дарга

Т.Шинэцэрэг

Шуурхай албаны дарга

Б.Батзориг